


Авлигатай тэмцэх газар авлигын эсрэг хууль тогтоомж болон байгууллагын стратеги төлөвлөгөө, 2022 онд дэвшүүлсэн зорилтыг ханган биелүүлэх чиглэлээр дараахь ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Онцлох ажлуудыг товчлон танилцуулж байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР: 2022 ОНЫ ОНЦЛОХ АЖИЛ

ГАДААД ХАРИЛЦАА

• Румын Улсын Авлигатай тэмцэх үндэсний газрын дарга, эрх бүхий албан хаагчид 2022 оны 5 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд Авлигатай тэмцэх газарт албан ёсны айлчлал хийлээ. Талууд айлчлалын хүрээнд албан ёсны уулзалт хийж, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд харилцан зөвшилцөх, мэдээлэл солилцох, авлигатай тэмцэх чиглэлд туршлага солилцох, шударга ёсыг дэлгэрүүлэх болон талуудын ашиг сонирхлын хүрээнд бусад салбарт хамтран ажиллаж хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал солилцов.

• Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 25 дахь удаагийн жилийн хурал, Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг шийдвэр гаргагчдын Өндөр түвшний уулзалт, Сүлжээний Удирдах зөвлөлийн 27 дугаар хурал, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын гишүүн орнуудын чуулган хоорондын уулзалт, Хөрөнгө буцаан авах



2022 оны 5 дугаар сарын 26-ны өдөр. Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал, Румын Улсын Авлигатай тэмцэх үндэсний газрын дарга, ерөнхий прокурор Криш-Никү Болога нар “Харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурав.

ажиллагааны талаарх олон улсын хурал, Ази, Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ (АРИН-АП)-ний жилийн бүгд хурал, Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээ (АСН)-ний Хууль сахиулагчдын 12 дугаар хурал, Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ (Globe)-ний гуравдугаар чуулган, НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 72 дахь удаагийн хуралдаан, “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц болон

түүний нэмэлт протоколуудын хэрэгжилтийн талаар Монгол Улсын тайлан боловсруулах, Алжир болон Ливан Улсын тайланг хянах” ажлын дэд хэсгийн хурал зэрэг олон улсын томоохон хурал, арга хэмжээнд тус тус оролцов.

• Авлигын эсрэг олон улсын академи (IACA)-аас дэвшүүлсэн Авлигын эсрэг дэлхийн хотуудын сүлжээ буюу “Global Anti-Corruption Cities Network” шинэ санаачилгад Улаанбаатар хотыг нэгдэн оруулах ажиллагаанд АТГ зохицуулагч байгууллагаар ажиллах боллоо.

• АТГ-ын албан хаагчид Бүгд Найрамдах Латви Улс, ХБНГУ-ын Авлигатай тэмцэх газарт айлчилж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

• Албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ (GlobE Network), АНУ-ын ЭСЯ, Холбооны Мөрдөх товчоо, Татварын хяналтын алба, Хуульчдын холбоо (ABA), Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис гэмт хэрэгтэй тэмцэх албаны Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга (StAR), БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хороо зэрэг байгууллагатай хамтран “Худалдаанд суурилсан мөнгө угаалт-НӨАТ-ын луйвар”, “Мөнгө угаалт, нябо бүртгэл, санхүүгийн аудит хийх аргачлал”, “Криптовалют, цахим ноглох баримт”, “Хөрөнгийн менежмент”, “Виртуал валютын тухай ахисан түвшний сургалт, санхүүгийн мөрдлөг” сэдвээр 8 удаагийн сургалтад давхардсан тоогоор 225 албан хаагчийг хамруулав.

НЭГ ӨГҮҮЛБЭРЭЭР

● НУБ-ын Авлигын эсрэг конвенц батлагдсаны 20 жилийн ойг угтан “Дэлхий нийтээрээ авлигын эсрэг нэгдье” уриан дор авлигын эсрэг олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлээ.

● Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага, Монголын Хөлбөмбөгийн холбоо, Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз, “Монголын олон суваг дамжуулагчдын холбоо”, Цагдаагийн ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулав.

● Авлигын төсөөллийн шалгуур үзүүлэлтийг бууруулах зорилго бүхий ажлын хэсгээс хэрэгжүүлэх эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлж тайланг хүргүүлэв.

● Байгууллагын хэмжээнд 2022 онд хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэл 471 нэгжээр буюу 20.4 хувиар, гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл 260 нэгжээр буюу 18.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

● E-Mongolia платформ дээр contact@iaac.mn хаягт хандан авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол гаргах тусдаа талбар үүсгэн мэдээлэл хүлээн авах цонхыг хэрэглээнд нэвтрүүлсэн.

● “11-11” тусгай утсаар төрийн байгууллагын хүнд суртал, авлигын шинж чанартай гомдол, мэдээллийг АТГ-ын 110 тусгай дугаарт шууд холбож, үйл ажиллагааг тогтмолжуулав.

● Нийслэлийн 6 дүүргийн 20 сургууль, 9 цэцэрлэгийн элсэлт болон нийслэлийн 9 дүүрэгт зохино байгуулагдсан хугацаат цэргийн албаны татлагын үйл ажиллагаанд тандалт хийж, хяналт тавьж ажилласан бөгөөд авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж өглөө.

● Эрүүл мэндийн яам, түүний харьяа 20 төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд ажиллаж, нийт 679 албан тушаалтныг хамруулж хянан шалгав.

● Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан 216 арга хэмжээний гүйцэтгэл 6.3 хувиар өссөн.

● 21 аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл дунджаар 77.6 хувь, яамдынх 76.0 хувьтай үнэлэгдэв.

● “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүк хуудаснуудын дагагчдын тоо 20394 хүнээр нэмэгдсэн байна. “Авлигатай тэмцэх газар” фэйсбүүк хуудсанд 308 нийтлэл оруулсан нь давхардсан тоогоор 3.097.413 хүнд хүрсэн. Өдөрт дунджаар 18.114 хүнд мэдээ, мэдээлэл хүрчээ. “110-Иргэдэд мэдээлэл өгөх аппликэйшн”-д сард 631 хандалт хийгдэж, нийт хандалтын тоо 16745 болсон байна. “iaac.mn” инстаграм хаягт судалгаа болон бусад пост оруулж, өдөр тутмын ажлын 113 түүх оруулсан. Тус түүх 1130 хүнд хүрчээ.

● “АТГ-ын мэдээлэл” телевизийн нэвтрүүлгийн 24 дугаарыг бэлтгэн орон даяар түгээв. Нэг нэвтрүүлгийг байгууллагын пэйж хуудсаар дамжуулан дунджаар 5000 орчим хүн үзжээ.

Сургалт, арга зүй

Авлигын эсрэг сургалтыг 340 удаа зохион байгуулж, 62077 хүнийг хамруулсан байна. Тусгайлан бэлтгэгдсэн 439 сургагч багш 278 удаагийн сургалт хийж, давхардсан тоогоор 78865 хүнийг хамруулсан бөгөөд сургагч багш нар тухайн салбар, байгууллага, орон нутагтаа 42 удаа соён гэгээрүүлэх өдөрлөг зохион байгуулсан нь 24033 хүнийг хамруулжээ.

Дүрэм журам хянах

Нийт 42 шийдвэр, дүрэм, журмыг хянаснаас хэм хэмжээний актад тавигдах ерөнхий ба тусгай шаардлагыг хангаагүй дүрэм, журмаас бүхэлд нь хүчингүй болгох тухай 23, өөрчлөлт оруулах 6, захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх 4 саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Саналын дагуу 2 шийдвэр хүчингүй болж, 3 шийдвэрийг хуульд нийцүүлжээ.

Соён гэгээрүүлэх контент

Авлигын нийгмийн хор аюулыг тайлбарлан таниулах сурталчилгааг цуврал шторк, тик ток, “Нэг дусал” контент, подкаст хэлбэрээр 64 төрлөөр бэлтгэж түгээсэн бөгөөд нийт 74480 ширхэг ном, гарын авлага, сурталчилгааны хуудас хэвлүүлж, галт тэрэгний тасалбар, орон сууц болон үйлчилгээний төвийн цахилгаан шат, сүлжээ дэлгүүр, гудамжны лэд дэлгэц, онлайн телевиз, кино театр зэрэг үйлчилгээ, байршлаар дамжуулан иргэдэд хүргэв.

Шалтгаан, нөхцөлийг арилгах

Авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгах, хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр төрийн байгууллага, албан тушаалтанд нийт 47 удаа Зөвлөмж хүргүүлэв. Эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн 53 мөрдөгчийн мэдэгдэл, 130 шаардлага, албан бичигт дурдсан зөрчил, гэмт хэргийг давтан гаргуулахгүй байхыг анхааруулав.

Уралдаан, тэмцээн



Багш нарын дундах хичээлийн хөтөлбөрийн уралдаанд ирүүлсэн 251 хөтөлбөрөөс 15 хөтөлбөрийг шалгаруулав.



“Түүний түүх” сэдэвт уралдаанд ирүүлсэн бүтээлээс сэдэвлэн богино хэмжээний кино контент, сурталчилгаа, нэвтрүүлэг хийнэ.



“Авлигын хор хөнөөл” гэрэл зургийн уралдаанаас шалгарсан 44 бүтээлээр үзэсгэлэн гаргаж, авлигын эсрэг постер, зурагт хуудас бүтээнэ.



“Оюутны эрдэм шинжилгээний илтгэл, эсээ бичлэгийн уралдаан”-д ирүүлсэн 23 илтгэл, 45 эсээг соён гэгээрүүлэх ажилд ашиглана.

Хэлэлцүүлэг, уулзалт

Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар цуврал хэлэлцүүлэг өрнүүлж, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг харьяалах салбар, байгууллагын албан тушаалтанд хүргүүлэв.

- “Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлоход тулгарч буй асуудал, цахимжуулалт, гарц шийдэл”;
- “Авлигаас ангид боловсрол: Ёс зүй ба шударга байдал”;
- “Эрүүл мэндийн даатгал-Иргэний хяналт-Эмнэлгийн тусламж, үйлчилгээ”;
- “Зам дагасан авлига”;
- “Барилгын салбар дахь авлигын эрсдэл ба инженерийн ёс зүй”;
- “Амьжиргаа дэмжих зөвлөлийн үйл ажиллагаа: уялдаа холбоо”;
- “Байгалийн нөөц ашиглалт: Орлого ба зарлага”;
- “Уул уурхайн салбар дахь авлигын эрсдэл ба гүйцэтгэх удирдлагын ёс зүй, ажлын үр дүнг тооцоо хь”;
- “Бизнест ёс зүйг эрхэмлэнэ” МҮХАҮТ-ын уулзалт;
- Аймгуудын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн сургагч багш нарын цахим уулзалт;
- “Монголын шүүгчдийн холбоо” ТББ-тай зөвлөлдөх уулзалт.

Олон нийтийг хамарсан өдөрлөг,

Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр дараах өдөрлөг, тусгайлан хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор **1.177.327** хүн хамрагдсан байна.

Иргэдэд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, зөвлөгөө, мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх арга хэмжээ.

“Нийтийн хөлбөмбөг” арга хэмжээнд “Зөв шүүлт-шударга тоглолт” иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх өдөрлөг.



Судалгаа шинжилгээ

Авлигын эсрэг хуульд заасан чиг үүрэг, байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын болон зорилтот судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- “Авлигын эрсдэлийн үнэлгээ”-г Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монголын төмөр зам ТӨХК, Баянзүрх дүүргийн Газар зохион байгуулалтын албанд хийж, судалгааны дүнг судалгаанд хамрагдсан дээрх байгууллагуудад танилцуулах ажиллагааг зохион байгууллаа.
- Шударга байдлын үнэлгээнд яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ буюу нийгдээ 78 байгууллагаас үйлчилгээ авсан нийт 15,160 оролцогч (10600 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, 2620 төрийн албан хаагч, 1940 шинжээч, бодлогод оролцогч)-ийг хамруулан зохион байгууллаа. Шударга байдлын үнэлгээгээр төрийн байгууллагууд 100 оноо авахаас дунджаар 73.9 оноо авсан нь 2021 оноос 1.0 пунктээр өссөн үзүүлэлт гарсан.
- “Хүүхдийн шударга байдлын судалгаа”-нд аймаг, нийслэлийн хэмжээнд 5605 сурагч, 2332 эцэг эх, 1334 багш, албан хаагч, нийт 9271 хүн хамрагдсан байна. Судалгааны дүнгээр хүүхдийн шударга байдлын түвшин 3.96 оноотой гарч өмнөх оноос 0.1 пунктээр буурсан үзүүлэлттэй гарсан.

ХАСХОМ-ийн хяналт шалгалт



Ашиг сонирхлын зөрчилд хамаарах гомдол, мэдээлэл

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан нийт

662 гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн.

Шийдвэрлэлт **95.6** хувьтай.



Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн

14695

иргэний ХАСУМ-ийг хянан шийдвэрлэж, холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн.



Өмнөхөөс **2227** нэгжээр өссөн.

НЭГ ӨГҮҮЛБЭРЭЭР

● Хуулийн хугацаанд төрийн болон нутгийн захиргааны нийт 120 байгууллагын **47554** мэдүүлэг гаргагч ХАСХОМ гаргаж бүртгүүлэв.

● Төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтны 2021 оны ХОМ-ийн хураангуйг <http://www.xasxom.iaac.mn> цахим хуудсанд нээлттэй байршууллаа.

● Мэдүүлгийн хяналт шалгалтыг эрсдэлд суурилан зохион байгуулж, үр дүнг тооцох ажлын хүрээнд **42657** албан тушаалтны ХАСХОМ-ийн мэдээлэлд эрсдэл тооцлоо.

● Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, түүний харьяа хараат болон охин, нийт 77 компанийн шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа удирдах болон эрх бүхий **404** албан тушаалтныг хуулийн үйлчлэлд хамруулж, ХАСХОМ гаргуулав.

● Хөрөнгө орлого нь 1 тэрбум, түүнээс дээш хэмжээгээр өссөн болон давтамжтайгаар өсч байгаа 24 албан тушаалтны цэвэр хөрөнгийн байдалд харьцуулсан дүн шинжилгээ хийж, энэ нь мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүдийн татварын орлоготой нийцэж байгаа эсэхийг хянуулахаар Татварын ерөнхий газартай хамтран шалгаснаар нийт **312.5** сая төгрөгийн шийтгэлийн хуудсаар төлбөр ногдуулсан дүнтэй байна.

● mediuleg.iaac.mn, iad.iaac.mn, e-office, smart.iaac.mn, search.iaac.mn, xasxom.iaac.mn цахим системүүдийг интеграцирлах, үйл ажиллагааг хөнгөвчлөх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх, системийн хэвийн найдвартай аюулгүй байдлыг хангах ажлыг гүйцэтгэж байна.

● Нийт мэдүүлэг гаргагчдын тоо өмнөх оноос **3861** нэгжээр нэмэгдсэн байна.

● Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын **1022** албан тушаалтан “хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт”-ийн талаар мэдүүлж, **34485** албан тушаалтан “тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүй илэрхийлсэн мэдэгдэл”, **389** нь “ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргасан байна.

● Ашиг сонирхлын зөрчилд хамаарах гомдол, мэдээллийг агуулгын хувьд авч үзвэл албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн 21.0 хувь, хууль бус шийдвэр гаргаж, бусдад давуу байдал олгосон 23.0 хувь, ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус томилгоо, шийдвэр гаргасан 22.0 хувь, хууль бус томилгоо хийсэн 27.0 хувь, бусад зөрчил 7.0 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон зөрчил 3.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

● Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр олон улсын гэрээний хүрээнд гадаад улсын нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа гүйцэтгүүлжээр БНХАУ-д 1, ОХУ-д 1, БНСУ-д 1, Швейцарь Улсад 1, Люксембург Улсад 1 эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хүргүүлснээс БНСУ-аас хариуг, БНЭУ-аас 2021 онд явуулсан 1 эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн хариуг хүлээн аваад байна.

соён гэгээрүүлэх арга хэмжээ

• “Зөв шүүлт-шударга тоглолт” иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх өдөрлөг.

“Хүнд сурталгүй цахим үйлчилгээ” өдөрлөг.

“Шударга байх хамгийн гоё” арга хэмжээ.

Аймгуудад “Авлигад үгүй гэж хэлье” өдөрлөг, “Зөв зөвд шударга зөв” аян.

“Таны эрх, таны оролцоо-Өнөөдрийг маргаашийн бахархал болгоё” соён гэгээрүүлэх өдөрлөг, “Залуучууд авлигыг тэвчихгүй” арга хэмжээ.



НЭГ ӨГҮҮЛБЭРЭЭР

● Хөгжлийн банктай холбоотой хэргүүдэд Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний 4/01 тоот тогтоолын дагуу Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын мөрдөгчдийн хамтарсан ажлын хэсгээр шалгуулах тогтоол гарсны дагуу Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/30, А/107 дугаартай хамтарсан тушаалаар нийт 26 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.

● Нийт мөрдөн шалгасан хэргийн 262-ыг шүүхэд шилжүүлэх саналтай, 389-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, 50-ийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 93 хэргийг нэгтгэн шалгаж, 11 хэргийг түдгэлзүүлж, одоо 715 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байна.

● Улсын Ерөнхий Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 4/04 дугаартай тогтоолыг үндэслэн Нүүрс олборлолт, экспорт, боомтын нүүрсний гээвэрлэлт, төлбөртэй холбогдсон хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/101, А/119, А/326 дугаартай тушаалын дагуу томилсон. Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 62 мөрдөгч ажиллаж, 32 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

● 2022 онд гэмт хэргийн шинжтэй нийт 1413 гомдол, мэдээллийг бүртгэлд оруулж шалгасан байна.

● Хүлээн авсан гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг холбогдсон албан тушаалын ангиллаар нь авч үзвэл төрийн тусгай 418, төрийн захиргааны 393, төрийн улс төрийн 233, төрийн үйлчилгээний 142, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн 158 этгээдийн, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын 69 байна.


● Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нийт 1413 гомдол, мэдээллээс 621 гомдол, мэдээлэл буюу 43.9 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 684 гомдол, мэдээлэл буюу 48.4 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 52 гомдол, мэдээлэл буюу 3.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 56 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 96.0 хувьтай байна.

● Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1413 гомдол, мэдээллийн 767 буюу 54.3 хувийг Улаанбаатар, 646 буюу 45.7 хувийг орон нутгийн прокурорын хяналтын харьяалалтай гомдол, мэдээлэл эзэлж байна.


● Эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 56 буюу 4.7 хувийг төрийн улс төрийн, 127 буюу 10.7 хувийг төрийн захиргааны, 103 буюу 8.7 хувийг төрийн тусгай, 84 буюу 7.1 хувийг төрийн үйлчилгээний, 814 буюу 68.8 хувийг бусад этгээд эзэлж байна.

Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл

2022 онд хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаархи гомдол мэдээлэл өмнөх оны мөн үеэс 350 нэгжээр өссөн.




Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн хэргийн тоо өссөн.




Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт

1806 үйлдэлтэй, 1184 холбогдогчтой, 1520 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь 16.3 хувиар өссөн байна.



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 52.2 хувьтай.


Ажиллагаанд байгаа хэрэг



Өнгөрсөн онтой харьцуулбал 235-аар өссөн байна.

Шүүхээр шийдвэрлэсэн хэрэг

188 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн нь 28 нэгжээр өссөн.



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт

Авлигын улмаас учирсан хохирол



Мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн дүн



Нийт учирсан хохирлын 47.3 хувийг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байна.

Битүүмжлэн хамгаалсан эд хөрөнгө, мөнгө



Хахуулийн 18,874,521,566 төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 5 дахин, нөхөн төлүүлэлт 24.7 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 4.3 дахин өссөн.

Гадаад улс орнуудаас авчирсан хөрөнгө

АТГ-ын мөрдөн шалгах ажиллагааны явцад 2021, 2022 онд гадаад улс орнуудаас нийт 12.2 сая ам. долларын өртөг бүхий хөрөнгийг буцаан авах үндэслэлийг тогтоож, шүүхийн шийдвэрээр улсын орлого болгосон. Үүнд:

- ИБУИНВУ-д байрлах 1 орон сууц, 1.8 тэрбум төгрөг (бэлэн мөнгө), 269.0 сая төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгө 2 ширхэг, нийт 6.4 тэрбум төгрөг буюу 4.7 сая ам. долларыг улсын орлого болгож,
- Британийн Виржинийн арлаас 2.2 тэрбум төгрөгийн буюу 1.6 сая ам.долларын үнэ бүхий газар, үл хөдлөх хөрөнгийг улсын өмчид бүртгүүлж,
- Мэн арлаас 11.3 тэрбум төгрөг буюу 5.7 сая ам, долларыг улсын орлого болгон хураан авсан байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүд:

- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ерөнхий захирал “Г”, тэргүүлэх мэргэжилтэн “Д” нарт холбогдох;
- Гаалийн ерөнхий газрын харьяа Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын дарга “М”-т холбогдох;
- Гашуунсухайт дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч “Э”-д холбогдох;
- Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын хэлтсийн дарга “Ж”-д холбогдох;
- НМХГ-ын Тамгын газрын дарга “Б” нарт холбогдох;
- ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга “Э”-д холбогдох;
- ЭМЯ-ны Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэргэжилтэн “Ч” нарт холбогдох;
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн захирал “Б” нарт холбогдох;
- ННҮГ-ын дарга “О” нарт холбогдох;
- СӨМҮТ-ийн ерөнхий захирал “Н”-д холбогдох;
- Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын Зам, замын байгууламж харууцсан мэргэжилтэн “А”-д холбогдох;
- НОБГ-ын дарга “У” нарт холбогдох;
- Сэлэнгэ аймгийн Автогэврийн төвийн дарга “Б”-д холбогдох;
- Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч “Т” нарт холбогдох;
- Дорнод аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга “М”-д холбогдох зэрэг хэргүүд анхан шатны шүүхээр тус тус шийдвэрлэгдээд байна.